БАТЛАВ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЦОГТГЭРЭЛ

2023 оны ..... дугаар сарын .....-ний өдөр

ХОВД АЙМАГТ 100 ГА ГАЗАРТ ХАДЛАН, ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ ГАЗАР БАЙГУУЛАХ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Гэрээгээр гүйцэтгэх ажлын дугаар: Төслийн 2023 оны ажлын төлөвлөгөөний 2.3.6 а

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1	Ажил гүйцэтгэх үндэслэл	Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн газар хамтран "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь" төслийг 2021 оны 3 дугаар сараас эхлэн Дорнод, Сүхбаатар, Завхан, Ховд аймагт хэрэгжүүлж байна. Төсөл хэрэгжсэнээр шууд байдлаар 130,000 орчим, шууд бус байдлаар 800,000 гаруй малчин иргэд төслийн үр шим хүртэхээс гадна тэдгээрийн 50 хувь нь эмэгтэйчүүд байна. Төслийн зорилго нь байгалийн нөөцөөс хамааралтай, уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий малчдын дасан зохицох, эрсдэлийг даван туулах чадамжийг сайжруулан бэхжүүлэх юм. Тус зорилгод хүрэхийн тулд хоорондоо уялдаатай дараах бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлэн үр дүнд хүрэх болно. Үүнд: Бүрэлдэхүүн хэсэг 1: Үндэсний болон бүс нутгийн түвшинд газар, усны нөөцийн төлөвлөлтийг уур амьсгалын мэдээлэлд тулгуурлан төлөвлөж, ашигладаг болох; Бүрэлдэхүүн хэсэг 2: Байгалийн нөөцийн менежментэд малчдын байгууллагын оролцоог нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон ус, хөрсний менежментийн арга ажиллагааг өргөн хүрээнд нэвтрүүлэх; Бүрэлдэхүүн хэсэг 3: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, гарал үүсэл нь тогтвортой малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх малчдын чадавхыг нэмэгдүүлэх зэрэг болно. Төслийн 2023 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны 2.3.6 а дугаар ажил дагуу Ховд аймгийн Манхан, Үенч, Буянт суманд 100 га талбайд хадлангийн нөөц талбайг хашиж хамгаалах хашаажуулах ажлыг хийж гүйцэтгэх ажилд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудын дунд зарлаж байна. Ховд аймгийн хувьд бэлчээрийн ус хангамж харьцангуй сайн, гэвч бэлчээрийн хүрэлцээ хангамж муу, бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн зэрэг асуудлуудтай байна. Бэлчээрийн даац дийлэнх сумдад олон дахин хэтэрсэн. Байгалийн ургамлын төрөл зүйл, тоо хэмжээ багасаж хөл газрын ургамал болон нэг наст, цөөн настын оролцоо өндөр болж байна. Ургамлын тэжээллэг чанар муудсан. Гангийн давтамж нэмэгдэж бэлчээрийн гарц, ургац муудаж байгаа. Булаг шанд ширгэж, түүний ундарга багасаж байна. Байгалийн хадлангийн гарц муудаж, эсрэгээрээ малчдын өвс тэжээлийн хэрэгцээ өсөн нэмэгдэж байна.

2	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Ховд аймгийн хэмжээнд экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хадлан тэжээлийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор байгаль цаг уурын өөрчлөлт, малын хөлд талхагдлаас сэргийлж байгалийн аясаар сэргээж, хамгаалах ажлыг зохион байгуулах.
3	Ажлын хамрах хүрээ	Ховд аймгийн Манхан, Үенч, Буянт суманд 100 га талбайд хадлангийн нөөц талбайг хашиж хамгаалах хашаажуулах ажлыг хийж гүйцэтгэнэ. Хадлан тэжээлийн нөөц газар байгуулж цөлжилт, байгалийн гамшигт үзэгдэл, байгалийн доройтлоос хамгаалах, бэлчээрийн зүй зохистой менежментийг хэрэгжүүлэх зорилгоор байгалийн онцлог тогтцыг ашиглан бэлчээрийн хязгаарын хамгаалалт /хоёр уулыг холбосон тор татах/ ажлыг хийж гүйцэтгэнэ. Ховд аймгийн Үенч суманд 40 га талбай хашиж хамгаална. Хашааны хэмжээ тухайн нөхцөл байдлаас хамаарч хэлбэлзэж болно. 1. Хужиртын ам /120м/ 2. Харгайтын бэлчир /90-100м/ 3. Их харгайтын ам /80-90м/ 4. Улиастайн хэвийн ам /110-120м/  Ховд аймгийн Манхан сумын Тахилт багийн Хөндлөнгийн ангист 30 га талбайд 2194 м хашаа барьж хадлан тэжээлийн нөөц газрыг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Тус талбайг сонгох үндэслэл боломж: • Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ган гачгийн давтамж нэмэгдэж байгаатай холбоотой усалгаатай талбайнуудыг ашиглах зайлшгүй шаардлагатай болж байна • Ил задгай услалтын системийг ашиглан хадлан, тэжээл авах боломж • Орон нутгийн өвс, хадлангийн эрэлт, хэрэгцээ • Бэлчээрийн доройтол, талхагдал ихтэй сум, бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн Талбайг сонгож сайжруулснаар гарах үр дүн: • Гадаргын ил задгай усыг ашиглан байгалийн хадлан тэжээл авах боломжтой • Нутгийн малчид, хоршоо, нөхөрлөл талбайгаас үр ашигаа хүртэх

- Доройтсон намаг бүхий бэлчээр сэргэх, түүнчлэн булгийн эх ундарга сайжрахад дам байдлаар нөлөөлөх

Сум	Баг	Өргөрөг	Уртраг
Манхан	2-р баг, Тахилт гол	47°17′49.49″N	92°16′03.67″E
		47°18′04.99″N	92°16′15.37″E
		47°17′57.76″N	92°16′39.04″E
		47°17′41.78″N	92°16′28.09″E

Ховд аймаг Манхан сум Хадлан тэжээлийн газар



Дарви	3-р баг, Мөрөн	46°55′09.91″N	93°18′38.04″E	2198
		46°55′05.95″N	93°19′02.37″E	
		46°54′47.77″N	93°18′54.43″E	
		46°54′52.14″N	93°18′30.97″E	

		Ховд аймаг Дарви сум Хадлан тэжээлийн газар 
4	Ажил гүйцэтгэх хугацаа	Ажил гүйцэтгэгч нь гэрээ байгуулагдсан өдрөөс хойш нийт 6 сарын хугацаанд багтаан тус ажлыг хийж гүйцэтгэнэ.
5	Захиалагч байгууллага	"Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь" төсөл
6	Төсөвт өртөг, тоо хэмжээ	Нийт төсөвт өртөг: **266 310 000 (Хоёр зуун жаран зургаан сая гурван зуун арван мянган төгрөг)** Нийт төсөвт өртөгт ажил гүйцэтгэгч багийн ажлын хөлс, орон нутагт ажиллах томилолт, тээврийн зардал гэх мэт тухайн ажил хийж гүйцэтгэхтэй холбоотой бүх зардал багтсан болно.
7	Ажил гүйцэтгэхэд тавигдах ерөнхий шаардлага	Ажлын гүйцэтгэх явцад бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНбД, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны холбогдох дүрэм журам, стандарт, төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн хамрах хүрээ, НҮБХХ-ийн байгаль орчин, нийгмийн стандарт чанд баримталж, хийгдэх ажлын тоо хэмжээний дагуу захиалагч талтай нягт хамтран, чанарын өндөр түвшинд тавигдсан шаардлагыг хангаж ажиллана. Орон нутгийн иргэдэд мэдээлэл түгээх, зөвлөлдөх, зөвшилцөх ажлыг орон нутагт хамтран зохион байгуулж, олон нийтийн оролцоог хангаж ажиллана.
8	Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага	ААН-ийн гэрчилгээний хуулбар /эх хувиас/ Санал болгосон ажлыг гүйцэтгэх боломжтой болохыг нотлох Ажил болон барааны үнийн задаргаа ба ажил гүйцэтгэлийн нийлүүлэлтийн хуваарь Чанарын шаардлага хангасан бараагаар уг ажлыг гүйцэтгэн захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, Чанарын баталгаа 1 жил /үйлдвэрлэгчээс шалтгаалсан гэмтэл, доголдлыг нийлүүлэгч тал засвар үйлчилгээ хийж гүйцэтгэх талаар нотолсон баталгааны талаар албан бичиг ирүүлэх/
9	Гүйцэтгэх ажлын үе шат	Ажлыг дараах үе шатаар гүйцэтгэнэ.Үүнд: 1. Бэлтгэл ажил: Хашааг хийх материалаа ажлын даалгаварт заасны дагуу сонгоно

		2. Үндсэн ажил: Ажлын даалгаварт заасны дагуу хэмжээ загвараар хашааг хийж гүйцэтгэх 3. Тайлан: Ажлын хэсэгт бэлэн болсон хашаагаа хүлээлгэн өгөх, захиалагч байгууллагаас техникийн хяналт хийлгэх, шаардлагатай бол засвар сайжруулалт хийх.
10	Хашаанд тавигдах техникийн шаардлага	Хашаанд тавигдах шаардлага: • Хашааны тор нь 3м урт, 1.5м өндөр, 5см*16см нүхтэй, 5мм голчтой утастай, цайрдсан төмөр тор байна. Тор нь шонтой бэхлэгдэх хэсгээрээ давхар утастай, гулзайлт сэнсрэлтээс хамгаалсан 3 хөндлөн нугалаатай байна. • Хашааны шон нь 2.5м урттай, 50мм голчтой, 2.5мм хананы зузаантай, цайрдсан төмөр труба байна. Шонг газарт 50см суулгана, газраас дээш өндөр нь 200см байна. Шонг 50-70мм голчтой дайрга, 10-20мм голчтой хайргатай хольж чигжиж суулгана (цемент ашиглахгүй). Шонгийн оройд таг (заглушка)-г гагнаж бэхэлнэ. • Хашааны 27 метр тутамд шонг хоёр талаас нь тулгуур шонгоор тулна. Тулгуур шон нь 2 метрийн урттай, 50мм голчтой, 2.5мм хананы зузаантай цайрдсан төмөр труба байна. Тулгуур шонг газарт 55см ухаж суулгах ба дээр дурдсан дайрга хайрганы холимогоор чигжинэ. Тулгуур шонгийн үзүүрийг хашааны шонгийн оройгоос 30см зайд хөдөлгөөнгүй бэхлэнэ. • Хашааны булангийн шонг 8мм-ээс багагүй голчтой төмөр утсаар эсвэл троссоор гадагш нь 2 чиглэлд татаж, газарт гадаслаж бэхэлнэ. • Хашааны торыг шон дээр 3-4 цэгээр боож бэхэлнэ. Бэхэлгээний төмөр ба боолт, гайх, шайб зэрэг нь мөн цайрдсан төмөр байна. Боолт тайлагдаж сулрахаас сэргийлж үзүүрт нь цэгэн гагнуур хийнэ. • Хашаа нь явган хүн болон машин орж гарах хаалгатай байна. Явган хүний хаалга нь 100см өргөн, 150см өндөртэй байна. Хаалганы самбарыг цайрдсан, 32мм голчтой трубагаар хүрээ зангидан, дээр дурдсан үзүүлэлт бүхий хашааны тороор дүүргэж, сайн чанарын нугас, түгжээ суурилуулж хийнэ. • Машин орж гарах хаалга нь 6 метрийн өргөн, 2м өндөр (3м урттай 2 самбар) байна. Хаалганы шон нь 150мм-с багагүй голчтой, 5мм-с багагүй ханын зузаантай, 2.7метрээс багагүй урттай, цайрдсан төмөр труба байна. Шонг газарт 70 см-ээс багагүй гүн суулгах ба БМ150 маркийн бетоноор цутгаж шонг бэхэлнэ. Хаалганы самбарыг цайрдсан, 32мм голчтой трубагаар хүрээ зангидан, дээр дурдсан үзүүлэлт бүхий хашааны тороор дүүргэж, сайн чанарын нугас, түгжээ суурилуулж хийнэ. Хаалганд гажилт, унжилтаас сэргийлсэн бэхэлгээ, тулгуур хийнэ. • Хашаанд 100х100 см хэмжээтэй, цайрдсан листэн төмрөөр хийсэн мэдээллийн самбар байрлуулна. • Хашааны булан бүрт мал шөргөөгч хийж байрлуулна. • Хашаанд шөнийн гэрэл цацруулагч байрлуулна.
11	Бусад тавигдах шаардлага	Хашаа барихдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд • Байгаль орчинд хор хөнөөл учруулахгүй халгүй арга технологиор хийгдсэн байна. • Хашаа малын хөлд үрэгдэхээргүй бат бөх байна. • Мал шөргөөгч тусад нь байрлуулах • Хашаа барих материал нь удаан эдэлгээтэй байна. • Газарт суулгаж буй шонг өмхрөх, ялзрал, зэврэлтээс хамгаалсан байна. • Шон тус бүрийн дотор талд мал түшиж унагаахаас хамгаалсан туслах хөлтэй

		байна. • Ашиглалтыг хариуцах эзэнтэй байна. • Торон хашааны материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологийн шийдэл бүхий байна. Монгол улсын стандартын шаардлагыг хангасан тохирлын гэрчилгээтэй байна. • Нийлүүлэх хашаатай ижил хашааны фото зургийг ирүүлэх бөгөөд ажлын гүйцэтгэл явуулах үед зөрүүгүй байна. • Ажлыг гүйцэтгэж дуусаад техникийн шаардлага хангасан гэж үзвэл захиалагчид далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг үйлдэж хүлээлгэн өгнө. • Материалын сонголтын саналыг захиалагчид ирүүлнэ. Тодорхойлолтод заагдсан болон түүнтэй дүйцэхүйц чанартайг сонгож хэрэглэнэ. • Галын аюулгүй байдлыг анхаарч норм дүрмийн шаардлагын дагуу ажлыг гүйцэтгэнэ. • Ажлаас гарсан хог хаягдлыг цэвэрлэж зөөж хаясны дараа захиалагчид хүлээлгэн өгнө. • Захиалагчийн хяналт болон ажил хүлээлцэхэд гарах зардлыг жишиг зураг төсвийн талбай бүрийн зохих дүнгээр тооцох бөгөөд гүйцэтгэгч тал бүрэн хариуцна. • Галын аюулгүй байдлыг анхаарч норм дүрмийн шаардлагын дагуу ажлыг гүйцэтгэнэ; • Ажлаас гарсан хог хаягдлыг цэвэрлэж зөөж хаясны дараа захиалагчид хүлээлгэн өгнө. • Ажлыг гүйцэтгэх явцдаа ажлын үе шат бүрд захиалагчид фото зургаар баталгаажуулан захиалагчид хүлээлгэн өгч үе шатны ажлыг эхэлнэ.
12	Даалгаварт тусгагдаагүй нэмэлт ажил	• Тус ажлын хүрээнд хадлан тэжээлийн нөөц талбайг хашаалан хамгаалсны дараа төслийн зөвлөх болон төслийн нэгжтэй хамтран байгалийн нөөц ашиглагч малчдын байгууллагуудтай байгалийн нөөц ашигласны гэрээг байгуулж тухайн орон нутгийн малчид иргэдэд хариуцуулж өгөх. • Ажлын даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

ТАНИЛЦСАН:

Уур амьсгалын өөрчлөлтийн

газрын дарга, Төслийн захирал: Ш.Цэрэндулам

ХЯНАСАН:

НҮБХХ-ийн хөтөлбөрийн шинжээч: Х.Хишигжаргал

Төслийн үндэсний зохицуулагч: Ю.Баяржаргал

БОЛОВСРУУЛСАН:

Төслийн газар, усны менежментийн

асуудал хариуцсан техникийн мэргэжилтэн Б.Гүнсмаа